МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр Дугаар А/421 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" захирамжтай холбоотой нэр бүхий иргэдээс гаргасан өргөдлийг шалган, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд:
Б.Отгончимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

З.Нямбаяр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодизи, зураг зүйн хяналтын Улсын байцаагч)

Б.Эрдэнэдалай (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:
Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

2. Өргөдөлтэй холбоотой асуудлыг шалган, дүгнэлт гаргаж 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6710011010